1992 онд ардчилсан шинэ Үндсэн хуулийг баталсны дараагаар хоёр танхимтай парламентыг халж, 76 гишүүнээс бүрдэх нэг танхимтай парламентын сонгуулийг шинээр зохион байгуулав. Тус сонгуульд нийт 8 улс төрийн нам, 2 эвсэл оролцсон ч Монголын Ардчилсан Нам, Монголын Үндэсний Дэвшлийн Нам, Монголын Ногоон Нам зэрэг шинээр байгуулагдсан намуудын эвсэл нь хуучин эрх баригч МАХН-ыг ялж чадаагүй. Улмаар тус ялагдлын дараагаар Монголын Ардчилсан Нам нь Монголын Үндэсний Дэвшлийн Нам, Монголын Сэргэн Мандлын Намтай 1992 онд нэгдэж, Монголын Үндэсний Ардчилсан Намыг байгуулжээ. Дараа нь 2000 онд МоАН, МҮАН, МСДН, МШАН зэрэг намууд нэгдэж либерал-консерватив Ардчилсан Намыг байгуулсан нь өнөөгийн хоёр дахь томоохон нам болсон юм (Амарсанаа, 2011). Хэдийгээр эдгээр намууд нэгдэж шинэ нам байгуулсан ч зарим гишүүд нь хуучин нэрээр шинэ нам байгуулсан нь олон төөрөгдлийг бий болгосон.

1990-ээд оны үеэр зөвхөн эдгээр намууд л хоорондоо нэгдэж нийлээгүй юм. Монголын Хувийн Өмчтөний Нэгдсэн Нам нь 1993 онд Монголын Малчид Тариачдын Нэгдсэн Нам, Монголын Тусгаар Тогтнолын Намтай нэгдэж Монголын Уламжлалын Нэгдсэн Намыг байгуулав. 1990-ээд оны эхэн үед байгуулагдсан намууд нь үзэл баримтлалд суурилсан гэхээсээ илүүтэй нийгмийн янз бүрийн давхаргыг төлөөлж байлаа.

2010 онд МАХН хуучин нэрээ сэргээх шийдвэр гаргаснаар тус намд тогтворгүй байдлыг бий болгосон. Тус намын дарга асан, МУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий Сайд асан Н.Энхбаяр тэргүүтэй зарим гишүүд нь уг шийдвэрийг эсэргүүцэж хуучин коммунист намын залгамж халааг үргэлжлүүлэхээр шийдвэрлэв. Улмаар 2010 онд Монгол Ардын Хувьсгалт Нам байгуулагджээ. Зүүн-төвийн үзэл баримтлал бүхий тус нам нь өнөөдрийн гурав дахь томоохон улс төрийн нам юм. МАХН 2012 оны УИХ-ын сонгуульд Монголын Үндэсний Ардчилсан Намын хамт Шударга Ёс эвслийг байгуулж, УИХ-д 11 суудал авсан (Бямбажав, 2012). Харин 2020 онд Иргэний Зориг Ногоон Нам, Монголын Уламжлалын Нэгдсэн Намтай эвсэж, УИХ-д 1 суудал авсан байна (Диеркис, 2020).

Монгол Улсын Дээд Шүүхэд 2020 оны 12 дугаар сарын байдлаар 36 улс төрийн нам бүртгэгджээ. Эдгээр намуудын талаас илүү нь сүүлийн 10 жилд бүртгүүлсэн байна. Гэхдээ ач холбогдол бүхий намуудын (relevant parties) тоо өсөөгүй гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй (Алтанхуяг, Ганхуяг, 2020). МАН ба АН-ын хоёр нам давамгайлсан системийг сөрөхийн тулд олон тооны жижиг намууд өнгөрсөн гучин жилийн хугацаанд хоорондоо нэгдэн нийлжээ. 2011 онд л гэхэд Иргэний Зориг Нам Монголын Ногоон Намтай нэгдсэн. Иргэний Зориг Нам нь энэ нэгдлээс өмнө 1992 онд байгуулагдсан Бүгд Найрамдах Намтай 2002 онд мөн нэгдэж байлаа.

Өнгөрсөн 2020 оны УИХ-ын сонгуульд харьцангуй шинээр байгуулагдсан улс төрийн нам УИХ-д суудалтай болсон. 2011 онд анх байгуулагдсан Хөдөлмөрийн Үндэсний Нам нь энэ сонгуулиар Монголын Социал Демократ Нам, Зүй Ёс Намтай эвсэл байгуулж, нэг суудал авчээ. Тус нам дотоод удирдлагын зөрчлөөс болж 2016 оны УИХ-ын сонгуульд оролцоогүй ба намын гишүүд нь мөн оны сонгуульд бие даан нэр дэвшсэн байдаг.

Эдүгээ хуучин коммунист намын залгамж халааг үргэлжлүүлэгч МАН нь социал-демократ зүүн-төвийн үзэл баримтлал бүхий нам юм. МАН өнөөдөр ч монголын улс төрд давамгайлсан хэвээр, намын систем дэх орон зайгаа хадгалсаар байгаа бол сөрөг хүчин АН сонгуульд шинээр үүсгэн байгуулагдсан намуудтай санал хуваах гэх мэт сорилттой тулгарах болов. МАН сүүлийн 8 удаагийн УИХ-ын сонгуульд дунджаар 44.5 хувийн санал авч, сонгогчдын дэмжлэг нь тууштай байж иржээ. Харин АН сүүлд зохион байгуулагдсан УИХ-ын сонгуульд ердөө 24.5 хувийн санал авч, сонгогчдын дэмжлэг нь анх нам байгуулагдах үе рүүгээ буцаж уруудах болов. УИХ-ын сүүлийн хоёр сонгуульд МАН УИХ-ын 76 суудлын 65 ба 62-ыг авсан бол АН ердөө 9 болон 11 суудалтай байлаа.

Монголын улс төрийн намуудын инстүүчлэл

Монголын парламентад суудалтай намуудын хувьсан өөрчлөлт буюу хууль тогтоох байгууллага дахь дэмжлэгийн түвшинг Хүснэгт 2-т дүрслэв. Өмнө дурдсанчлан МАН ба АН гэсэн хоёр нам л сонгууль бүрт суудал авчээ. Харин хоёроос дээш удаа сонгуулиар суудал авсан одоогийн УИХ дахь өөр нэг нам нь МАХН юм. Иймээс бид гурван улс төрийн намыг өдгөө УИХ-д төлөөлөлтэй буй ХҮН-ын хамтаар инстүүчлэлийн түвшинг нь шинжлэхээр шийдсэн юм.

Хүснэгт 1. 1992 оноос хойших УИХ-д суудалтай улс төрийн намууд²

Намууд	1992	1996	2000	2004	2008	2012	2016	2020
МАН	70	25	72	36	45	25	65	62
АН	5	50	1	34	28	31	9	11
МАХН						11	1	1
ХҮН								1
ИЗНН			1		1	2		
МУНН		1						
БНН				1				
МАШСН			1					

Эх сурвалж: СЕХ (2020)

2 Хэдийгээр 1990 оны сонгууль нь анхны чөлөөт, шударга сонгууль байсан ч бид 1992 оноосхойших сонгуулиудыг дүн шинжилгээндээ ашиглалаа. 1992 онд ардчилсан Үндсэн хууль батлагдсан учир бид 1992 оны сонгуулийг эх үндэс тавьсан сонгуульд тооцов.

Монголын улс төрийн намуудын инстүүчлэл

Энэ хэсэгтээ бид намын инстүүчлэлийн есөн шалгуур үзүүлэлтүүдийг нэг бүрчлэн авч хэлэлцэх болно. Бид өмнө дурдсанчлан намын нас, сонгогчдын саналын тогтвортой байдал, намын дэмжлэг (party identification), намын гишүүнчлэл, намын үндэсний хэмжээнд хүрсэн байдал, байгууллага, удирдлагын тогтвортой байдал, нам сэлгэлт (гишүүнчлэл) зэргийг энд авч үзэх болно. Эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь монголын улс төрийн намууд нийгэмд хэр зэрэг суурьтай буюу гишүүд төдийгүй сонгогчиддоо хүрч буй эсэхийг, мөн байгууллагын хувьд дотор болон гаднаа хэр тогтвортой байгааг таних боломж олгоно. Учир нь Мейнверинг, Скалли нарынхаар намууд “бүтэц нь бат суурьтай, нутаг дэвсгэрийн хэмжээнд цогц зохион байгуулалттай, өөрийн нөөцтэй” тохиолдолд инстүүчлэгдсэн байдаг (1999, 27).

Намын нийгэм дэх суурь (**Social Rootedness**)

Намуудын нийгэм дэх үндэс суурийг хэмжихдээ намуудын насаар хэмжих нь нийтлэг байдаг. Гол санаа нь “намын нас өндөр байх тусмаа удаан хугацаанд иргэдийн дэмжлэгийг авч чадсан гэсэн үг юм” (Dix 1992, 491). Тийм ч учраас энд зөвхөн олон намын тогтолцоотой болсноос хойш буюу чөлөөт сонгууль хийж эхэлснээр тооцож үздэг.

Хүснэгт 2. Намуудын нас

Намууд	Намын нас
МАН	30
АН	20
МАХН	9
ХҮН	9

Эх сурвалж: УДШ (2020)

Өмнө дурдсанчлан Монгол Улсад 2020 оны 12 дугаар сарын байдлаар 36 улс төрийн нам үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрийн талаас илүү нь сүүлийн 10 жилд үүсгэн байгуулагджээ. Хүснэгт 2-т 2020 оны эцсийн байдлаар монголын парламентад суудалтай улс төрийн намуудын насыг харуулав. Эдгээрээс хамгийн олон урт настай нь МАН байна. Түүний дараагаар 1990 онд байгуулагдсан таван намын нэгдлээр 2000 онд үүсч бий болсон АН хоёрдугаарт жагсаж байна. МАН-аас салсан МАХН нь ХҮН-ын адил үүсгэн байгуулагдаад 9 жил болжээ³. Өнөөдрийн байдлаар эдгээр намуудын дундаж нас 17 жил байна.

3 МАН ба МАХН нь 1921 онд үүсгэн байгуулагдсан коммунист намыг залгамжлагч учир өөрсдийгөө 100 жилийн түүхтэйд тооцдог. Мөн АН нь 1990 онд үүсгэн байгуулагдсан 5 намын нэгдлийн дунд

Монголын улс төрийн намуудын инстүүчлэл

Сонгогчдын саналын тогтвортой байдал

Энд бид сонгогчдын саналын тогтвортой байдал хэмээх шалгуур үзүүлэлтээр эдгээр дөрвөн намын сонгогчдын дэмжлэг 1992 оноос хойш хэр тууштай буйг хэмжлээ. Хэрэв тухайн намын нэг сонгуулиас нөгөө сонгуулийн хооронд авсан саналын хувь хэмжээ бараг ойролцоо тохиолдолд уг нам сонгуулиар тууштай дэмжигсэдтэй буюу нийгэмдээ үндэс суурьтайд тооцогдоно. Харин тийм биш бол нийгмийн холбоос сул гэж үзнэ.

Хүснэгт 3. Сонгогчдын тогтвортой байдал

Намууд	1992-1996	1996-2000	2000-2004	2004-2008	2008-2012	2012-2016	2016-2020
МАН	12.9	10.5	3	4.9	11.8	13.8	0.1
АН	21.1	22.5	18.8	4.7	4.1	2.2	8.6
МАХН						14.3	0.1
ХҮН							

Эх сурвалж: судлаачдын тооцолол

Сонгуулиудынхоорондсонгогчдын дэмжлэг (хувь хэмжээгээр) хэрхэн өөрчлөгдсөнийг Хүснэгт 3-т үзүүлэв. Хүснэгтэд харуулсанчлан томоохон гурван нам тогтвортой буюу дундаж хэмжээнд дэмжлэгээ хадгалж иржээ. МАН-ын зарим гишүүд МАХН-ыг байгуулж, бүтцийн өөрчлөлт орсныг эс тооцвол гурван нам гурвуулаа сонгогчдын дэмжлэгээ хадгалсаар байна⁴. Ялангуяа сүүлд болсон сонгуулиар Ковид-19 цар тахалтай байсан хэдий ч МАН ба МАХН хоёулаа бараг ижил саналын хувь хэмжээ авсныг эндээс маш тодорхой харж болно.

Намын дэмжлэг (identification)

Намын дэмжлэг тогтвортой байх нь намуудын тууштай өрсөлдөөнийг нэмэгдүүлж, системийн түвшний инстүүчлэлд нөлөөлдөг. Намууд нийгэмд суурьтай үед тэдний үзэл баримтлал нь тууштай, бас сонгуулийн үр дүн урьдчилан таамаглахуйц байдаг.

4 Хэрэв МАН болон МАХН-ын хоёулангийнх нь 2012 онд авсан сонгуулийн дэмжлэгийг МАН (эх нам)-ын 2008 оны саналын хувь хэмжээтэй харьцуулбал тус хоёр намыг дэмжигчдийн хувь хэмжээ дөрвөн жилийн өмнөхөөсөө ердөө 10.5 хувиар өндөр байгааг харж болно.

Хүснэгт 4. Аль нэг намыг онцолж дэмждэг гэж хариулсан хүмүүсийн хувь хэмжээ

2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
44.9%	46.1%	50.3%	46.3%	44.5%	37.3%	36.9%	N/A	32.0%	26.1%

Эх сурвалж: Сант Марал Сан

Монголд санал асуулгаар аль нэг намыг онцолж дэмждэг гэж хариулсан хүмүүсийн хувь хэмжээ сүүлийн 10 жилд буурч буйг Хүснэгт 4-өөс харж болно. 2010 онд санал асуулгад оролцогчдын ойролцоогоор 45 хувь нь аль нэг намыг онцолж дэмждэг гэж хариулсан бол 10 жилийн дараа энэ тоо бараг 19 хувиар буурчээ (ойролцоогоор 26 хувь хүртэл).

Намын гишүүнчлэл

Намын гишүүнчлэлийг хэмжих нь намын сонгогчдын дэмжлэг болон намууд, сонгогчид хоорондын холбоос хэр хүчтэй буйг тодорхойлоход туслана (Mair, 2005; Mair & van Biezen, 2001; van Biezen, Poguntke & Mair, 2012). Монголын намуудын гишүүнчлэлийн түвшин тогтвортой хэмжээнд буюу нийт сонгогчдын 15 хувь хавьцаа байна.

Хүснэгт 5. Намын гишүүнчлэл

Намууд	Гишүүд	
	Албан	Албан бус
МАН	161 300	201 267
АН	150 000	70 000
МАХН	35 000	30 000
ХҮН	1 024	1 500

Эх сурвалж: УДШ (2020)

Уг судалгаанд хамруулсан дөрвөн намын нийт гишүүнчлэлийн тоог хүснэгт 5-д харуулав. МАН гишүүнчлэлийн тоогоороо 1990 оноос хойш хамгийн том нь байж иржээ. Тус нам өнөөгийн байдлаар 200 мянга гаруй гишүүдтэй бол сөрөг хүчин АН улсын хэмжээнд 70 мянга орчим гишүүдтэй байна. МАХН-ын хувьд шинээр үүсгэн байгуулагдсан бусад намуудтай харьцуулахад гишүүнчлэлийн тоогоороо хамгийн их буюу ойролцоогоор 30 мянган гишүүнтэй байна. Эдгээр дөрвөн намаас ХҮН нь хамгийн цөөн буюу 1000 орчим гишүүдтэй бөгөөд тус намыг дэмжигчид голдуу хотод төвлөрчээ.

Шинээр үүсгэн байгуулагдсан жижиг намууд МАН болон АН-ын гишүүнчлэлийн тоо хэмжээг давж гарахад бэрхшээлтэй байдаг. Хүснэгт 5-д харуулсанчлан энэхүү хоёр

Монголын улс төрийн намуудын инстүүчлэл

нам гишүүнчлэлийн хувьд нийгэмд харьцангуй хүчтэй суурьтай байна. Түүнчлэн 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр улс төрийн намуудын бүртгэлийн шаардлагад өндөр босго тогтоож, дээрх байр суурь улам бэхжих нөхцөл бүрдсэн⁵. Уг өөрчлөлтөөс өмнө намуудын бүртгэлд 801 гишүүнтэй байх шаардлагыг тавьдаг байв.

Намын үндэсний хэмжээнд хүрсэн байдал

Намын инстүүчлэлийн бас нэгэн шалгуур үзүүлэлт нь намын үндэсний хэмжээнд хүрсэн байдал юм. Уг шалгуураар тухайн намын сонгогчдын дэмжлэг нийт бүс нутгаар тогтмол эсэхийг хэмждэг. Аливаа улс төрийн намын сонгогчдын дэмжлэг орон даяар тууштай, ойролцоо бол инстүүчлэгдсэн гэж үзнэ. Харин эсрэгээрээ сонгогчдын суур-дэмжлэг, нь орон даяар доогуур бол тухайн намыг үндэс суурь султай буюу инстүүчлэгдээгүйд тооцно (Mainwaring & Scully, 1995: 11; Meleshevich, 2006: 115). Судлаачид намын инстүүчлэлийн олон янзын индексүүдийг санал болгосон байдаг (Jones & Mainwaring, 2003; Kasuya & Meonious, 2008; Boschler, 2010). Ийм цогц нарийн хэмжүүрийг тооцоход шаардлагатай өгөгдөл байгаагүй учир бид монголын улс төрийн намуудын хот (нийслэл хот), орон нутаг дахь сонгогчдын дэмжлэгийн ялгааг харуулахаар шийдлээ (Хүснэгт 6). Сайн хөгжсөн, хүчтэй улс төрийн намуудын гол онцлог шинж чанар бол дан ганц хот эсхүл хөдөө орон нутагт бус улс даяар “нэвтрэх” чадвар юм (Huntington, 1968; Rokkan, 1970).

Хүснэгт 6. Намын үндэсний хэмжээнд хүрсэн байдал

Намууд	1992	1996	2000	2004	2008	2012	2016	2020
МАН	12.8	9	1.5	3	14.2	12.7	10.9	4.3
АН	1	1	3	3.9	3.9	1.3	8.7	15
МАХН						9.2	4.3	1.5
ХҮН								8.3

Эх сурвалж: судлаачдын тооцоолол

Хүснэгт 6-д харуулсанчлан АН хамгийн үндэсний хэмжээний улс төрийн нам байна (Оноо бага байх тусмаа илүү үндэсний хэмжээнд хүрсэн гэж ойлгоно). Сүүлийн хоёр сонгуулийг эс тооцвол сонгогчдын дэмжлэг нь Улаанбаатар хот болон бусад газруудад ч тэнцвэртэй хэвээр байна. Хамгийн ойр дөхөх нь МАХН бөгөөд “элитийн нам” гэгдэх анхны төсөөллөө (2012 онд) сольж, хөдөө орон нутагт ихээхэн дэмжлэг олж авч чаджээ. Харин ХҮН нь голдуу хотынхныг хамарсан нам гэдгийг харуулж

5 Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн дагуу улс төрийн намууд нийт сонгогчдын нэгхувиас багагүй тооны гишүүдтэй байх ёстой. 2020 оны байдлаар 2 003 969 сонгогч бүртгэгдсэн байгаа нь улс төрийн намууд багадаа 20 000 гишүүнтэй байх ёстой гэсэн үг. Уг нэмэлт, өөрчлөлтийн зүйл заалт нь 2028 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэнэ.

байна. Тиймээс тэд үндэсний хэмжээнд хүрсэн байдал хамгийн сул аж.

Сонирхолтой нь МАН монголын улс төрийн орчинд тасралтгүй давамгайлж ирснээс гадна тус намын коммунист үеэс залгамжилсан байгууллагын бүтэц орон нутагт илүү хадгалсаар байна. Үүнд нэг тохиолдлыг эс тооцвол (2000 он, хавсралт хэсгээс хүснэгт С-г харна уу) МАН орон нутагт сонгогчдын дэмжлэгийг хамгийн их авч байна. Түүнчлэн МАН гурван удаа сөрөг хүчиндээ ялагдал хүлээжээ (1996, 2008⁶, 2012).

Монголын намуудын үндэсний хэмжээнд хүрсэн түвшин ялгаатай буйг харуулах эцсийн нотолгоо бол АН болон МАХН хоёул нийслэл хот, хөдөө орон нутаг дахь сонгогчдын дэмжлэгээ нэг сонгуулиас нөгөө сонгуульд тууштай хадгалж чадсан явдал юм (хүснэгт С-г харна уу). Тус хоёр намтай харьцуулбал МАН зөвхөн орон нутгийн сонгогчдын дэмжлэгийг илүү тууштай авч ирснийг харж болно.

Бүтцийн тогтворгүй байдал

Улс төрийн намуудын байгууллагын хувьд харах нэг үзүүлэлт бол ямар хэмжээнд бүтцийн өөрчлөлт гарсан гэдгийг хэмжих юм. Үүний дагуу бид монголын улс төрийн намууд ардчилалд шилжсэнээс хойш задарч, нэгдсэн тоог энд харуулна.

Сүүлийн гучин жилийн хугацаанд нэг намын ноёрхлыг давж гарахын тулд олон жижиг намуудад задрах, нэгдэх үйл явц өрнөсөн. Монголын улс төрийн намууд ардчилсан хувьсгалаас хойш бүтцийн тогтворгүй байдал, намын удирдлагууд хоорондын зөрчлөөс болж олон удаагийн задрал, нэгдэл амсчээ. Монгол Улсын Дээд Шүүх улс төрийн намуудыг бүртгэхдээ олон маргаантай шийдвэрүүдийг гаргасан байна. Зарим улс төрийн намууд хоорондоо нэгдэх үед тухайн нэгдлийг эсэргүүцэж байсан гишүүд нь хуучин нэрээр шинэ нам байгуулж байв. МАН-ын 2011 оны задралыг эс тооцвол тус нам үүсгэн байгуулагдсанаасаа хойш монголын хамгийн тогтвортой улс төрийн нам байж иржээ. Энэхүү судалгаанд хамрагдсан дөрвөн намын хувьд авч үзвэл ердөө дөрвөн тохиолдол гарсан байна (Хүснэгт 7-г харна уу).

Хүснэгт 7. Байгууллагын залгамж халаа

Намууд	Задрал	Нэгдэл
МАН	1	0
АН	1	1
МАХН	0	0
ХҮН	0	0

Эх сурвалж: судлаачдын тооцоолол

⁶ Энэ нь МАН-ын орон нутгийн чансааг харуулсан хамгийн тод жишээ байсан бол удаах ньүүнд сонгуулиар ялахад тусалжээ.

Монголын улс төрийн намуудын инстүүчлэл

Эдгээрээс хамгийн эхнийх нь өнөөгийн Ардчилсан Нам 2000 онд Монголын Үндэсний Ардчилсан Нам, Монголын Социал Демократ Нам, Монголын Шашинтны Ардчилсан Нам, Монголын Сэргэн Мандлын Нам, Монголын ардчилсан нам хоорондоо нэгдсэнээр анх үүсч бий болжээ.

МАХН нь ардчилсан шилжилтийн үед харьцангуй тогтвортой явж ирсэн. Гэвч тус нам 2010 онд нэрээ МАН болгон өөрчилсөн явдлыг намын зарим гишүүд нь эсэргүүцэх болсноор задарсан. МАН-ын дарга асан Н.Энхбаяр болон намын зарим гишүүд намаа орхиж, шинээр нам байгуулсан нь өнөөгийн МАХН юм.

Эцэст нь 2020 оны УИХ-ын сонгуулийн өмнө АН-д өрнөсөн жижиг хэмжээний задралаар ШИНЭ Нам (Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл Нам) үүсгэн байгуулагдав. Ж.Батзандан, Лу.Болд зэрэг АН-аас сонгогдсон УИХ-ын гишүүд нь тус намыг үндэслэгчид юм. АН-ын Үндэсний Дүрмийн Хороо 2018 онд Ж.Батзандагийн гишүүнчлэлийг цуцалж, Лу.Болдыг тус намаас УИХ-ын сонгуульд нэр дэвших эрхийг 4 жилээр хязгаарлах шийдвэрийг гаргаж байв. 1990 оны Ардчилсан хувьсгалд манлайлагч, мөн үеэс хойш тус намын гишүүн байсан Лу.Болд нь уг шийдвэрийг эсэргүүцэж, намаасаа гарсан юм. АН намаасаа сонгогдсон хоёр гишүүнээ алдсаны үр дүнд УИХ дахь намын бүлгээ тараахад хүрчээ. ШИНЭ Нам нь өнгөрөгч УИХ-ын сонгуульд өрсөлдөхдөө Бүгд Найрамдах Нам, Үнэн ба Зөв Нам, Монголын Үндэсний Ардчилсан Намтай эвсэл байгуулсан. Хэдийгээр тус сонгуульд нийт сонгогчдын 5 хувийн дэмжлэг хүлээсэн ч УИХ-д суудалтай болж чадаагүй юм.

Нам сэлгэлт (гишүүнчлэл)

Улс төрийн намуудын зан үйлийн хэвшмэл байдлыг хэмжих өөр нэг арга нь нам сэлгэлт (гишүүнчлэл) юм. Үүнийг нэг намаас парламентад сонгогдоод дараа нь өөр намын харъяалалтайгаар парламентад ахин сонгогдсон гишүүдийн тоо хэмжээгээр тодорхойлдог. Юуны өмнө намаа сольсон амжилттай тохиолдлуудыг (өөр намын харъяалалтайгаар дараалсан сонгуулиудад ялалт байгуулсан намын гишүүдийг энд тооцно) л авч үзсэн учир бид ердөө 3 тохиолдлыг олж тогтоолоо. 2008 онд АН Эх Орон намаас нэг гишүүнийг (Х.Баттулга) элсүүлсэн бол 2016 онд МАХН хоёр гишүүнээ (Ч.Улаан, Д.Тэрбишдагва) МАН-д алджээ.

Харин нам сэлгэсэн 5 амжилтгүй тохиолдол бүгд АН-д харъяалагдаж байв. 2016 оны УИХ-ын сонгуулийн өмнө хоёр гишүүн (МАН-ын гишүүн Д.Арвин, ИЗНН-ын гишүүн С.Дэмбэрэл) АН-д элсэхээр өөрсдийн намаа орхисон. Гэвч шинээр нэгдэж орсон эдгээр гишүүд 2016 оны сонгуульд ялж чадаагүй.

Түүнчлэн АН хоёр гишүүнээ (Лу.Болд, Ж.Батзандан) алдсаныхаа дараа 2020 онд МАХН-ын нэг гишүүнийг (О.Баасанхүү) намдаа элсүүлсэн байна.

Хүснэгт 8. Нам сэлгэлт

Намууд	Амжилттай тохиолдол		Амжилтгүй тохиолдол	
	2008	2016	2016	2020
МАН		2	1	
АН	1		2	3
МАХН			2	1
ХҮН				

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Өөр намын харъяалалтайгаар дараагийн сонгуульд ахин сонгогдсон гишүүдийн тоо хэмжээг хүснэгт 8-д харуулав. МАН нь нам сэлгэлтээс хамгийн их давуу тал олсон бол АН амжилтгүй сэлгэлтүүдээс хамгийн их хохирол амсчээ.

Удирдлагын өөрчлөлт

Удирдлагын өөрчлөлт бол байгууллагын түвшин дэх намын инстүүчлэлийн нэг чухал шийдвэрлэх хэмжүүр юм. Гарааны үедээ тогтвортой удирдлагатай байх нь намуудыг цааш оршин тогтноход чухал хэдий ч намын дотоод ардчиллын хувьд авч үзвэл үндсэн дүрэм, журмаа хэрэгжүүлэхийн тулд удирдлагаа сольдог байх ёстой. Ийм учраас инстүүчлэгдсэн намууд удирдах түвшинд гарсан дотоод зөрчилтэй холбоотой сорилтуудаа даван туулах ёстой гэсэн үг (Дикс, 1992). МАН-ын удирдлага сүүлийн гучин жилийн хугацаанд хамгийн олон солигдсоныг Хүснэгт 8-аас харж болно. Харин МАХН-ын хувьд огт солигдоогүй байна. Иймээс МАН байгууллагын залгамж халаагаараа хамгийн инстүүчлэгдсэн нам гэдэг нь тодорхой байна.

Хүснэгт 9. Удирдлагын сэлгээ

Намууд	Дарга солигдсон тоо
Монгол Ардын Нам	11
Ардчилсан Нам	7
Монгол Ардын Хувьсгалт Нам	0
Хөдөлмөрийн Үндэсний Нам	3

Эх сурвалж: УДШ (2020)

Намын дарга нарын албан тушаалдаа байх хугацаа МАН-д дунджаар 2.6 жил байна. Ерөнхийлөгч, Ерөнхий Сайд асан Н.Энхбаяр нь МАН-ын сүүлийн гучин жилийн түүхэн дэх хамгийн удаан алба хашсан дарга юм. Тус нам 2011 онд МАН болон МАХН гэсэн

Монголын улс төрийн намуудын инстүүчлэл

хоёр нам болж задрахаас өмнө тэрээр нийт 8 жилийн турш дарга байжээ. Тэрээр хуучин намаасаа салсны дараагаар МАХН үүсгэн байгуулагдсанаас хойших цорын ганц дарга нь байв. Угтаа тус нам нь монголын улс төрийн түүхэнд МАН ба АН-ын давамгайллыг сорьсон цорын ганц нам юм. Гэвч МАХН түүний удирдлаганд 2016, 2020 оны дараалсан сонгуулиудаар ердөө нэг суудал авч, парламентад төлөөлөлтэй болсон.

Сонгуулийн ялагдал нь сөрөг хүчин АН-ын удирдлагад өөрчлөлт авчирдаг байна. Уг нам Ардчилсан хувьсгалын манлайлагчдын удирдлага дээр боссон шигээ дийлэнх дарга нар нь үүнд хамааралтай хувь хүмүүс байжээ. Намын дарга нар нь дунджаар 2.7 жил албан тушаалдаа байдаг. Тус нам 2000 онд албан ёсоор үүсгэн байгуулагдсанаас хойш Ерөнхий Сайд асан Н.Алтанхуяг намын даргын албан тушаалыг хамгийн удаан хашжээ. Тэрээр 2014 онд Ерөнхий Сайдаасаа огцрох хүртлээ 8 жилийн турш намын дарга байв. УИХ-ын өнгөрсөн хоёр сонгуулийн дүнгийн улмаас тус нам сүүлийн жилүүдэд дотоод шинэчлэлүүд хийсэн. АН 2016 оны сонгуулийн ялагдлынхаа дараагаар гишүүдийн санал хураалтаар намын даргаа сонгох процедур нэвтрүүлсэн. Үүний дагуу бүх гишүүдийн шууд санал хураалтаар сонгогдсон анхны намын дарга нь С.Эрдэнэ юм. Гэвч тэрээр өнгөрсөн сонгуулийн үр дүнгийн улмаас албан тушаалаа өгсөн.

Хүснэгт 9-т харж байгаачлан ХҮН гурван удаа намын даргаа сольжээ. Хэдийгээр сүүлд болсон УИХ-ын сонгууль тус намын анхны сонгуулийн өрсөлдөөн байсан хэдий ч МАХН-тай харьцуулахад илүү олон удаа намын даргын өөрчлөлт хийжээ.

Байгууллагын бүтэц

Намд байгууллагын бүтцийн хамрах хүрээ мөн чухал үзүүлэлт юм. Намуудын дотоод шийдвэр гаргах, зөвлөлдөх үйл явц, мөн нэр дэвшигчид, албан тушаалтнуудаа элсүүлэх журам тогтсон эсэх нь чухал. Өөрөөр хэлбэл намын байгууллагын бүтэц нь нутаг дэвсгэрийн хэмжээнд цогц, баттай суурьших (мөн хүний бусад нөөцийн хувьд) тусмаа илүүтэй инстүүчлэгдсэнд тооцогдоно (Szczerbiak, 2001).

Хүснэгт 10. Байгууллагын бүтэц

Бүтэц	МАН	АН	МАХН	ХҮН
Гишүүдийн тоо	201 267	70 000	30 000	1 500
Дэмжигчдийн тоо		180 000	300 000	20 000
Намын үүр	Улаанбаатар хотод 538, хөдөө орон нутагт 2178	Улаанбаатар хотод 172, хөдөө орон нутагт 172	900	10
Салбарууд	Хороо бүрт 3-4 нэгж	Сум, хороо бүрт 1 нэгж	Бүх аймаг, сум, хороонд	Улаанбаатар хотын 6 дүүрэг болон Дархан, Эрдэнэт, Булган, Увс аймагт
Ажилчдын тоо	Аймаг бүрт 4-5, сум бүрт 1-2		Нэгж тус бүрт 1	30
Гишүүнчлэлийн хураамж	1000 төг	12 000 төг, 500 000 төг, 1.5 сая төг, 3 сая төг	1 000 төг, 10 000 төг, 100 000 төг, 1 сая төг	12 000 төг

Эх сурвалж: судлаачдын ярилцлагын үр дүнгээр

Монголын томоохон улс төрийн намуудын салбар, нэгж, ажилчдын тоог хүснэгт 10-т харуулав. Эндээс МАН шинээр үүсгэн байгуулагдсан ХҮН зэрэг бусад намуудтай харьцуулахад хамаагүй олон салбар, нэгжтэйг харж болно. Монголын улс төрийн намууд байгууллагын бүтцийн хувьд коммунист өв уламжлалаасаа (нам-төрийн загвартай) түүхэн хамааралтай байна. Тийм учраас намууд засаг захиргааны нэгж бүрт салбараа байгуулах гэж оролддог. МАХН АН-аас залуу хэдий ч илүү олон салбар, нэгжтэй байна. Гэхдээ МАН болон АН илүү олон үндсэн ажилчидтай бол МАХН, ХҮН нь илүүтэй сайн дурын үндсэн дээрх байгууллагын бүтэцтэй гэдгийг хэлэх нь зүйтэй.

Монголын улс төрийн намуудын инстүүчлэл

Дүгнэлт

Энэхүү өгүүлэлд хэмжсэн гол тооцооллуудыг хүснэгт 11-т хураангуйллаа. Дундаж үзүүлэлт нам тус бүрээр төдийгүй үндэсний түвшинд ямар байгааг харуулав. Гол зорилго нь монголын улс төрийн намуудын инстүүчлэлийн түвшинг дээр дурдсан хэмжигдэхүүнүүдээр хэмжих байсан билээ.

Хүснэгт 11. Монголын намын инстүүчлэл

Намууд	Нас	Тогтворгүй байдал	Дэмжлэг	Гишүүнчлэл	Үндэсний хэмжээнд хүрсэн байдал**	Залгамж халаа***	Сэлгэлт****	Удирдлагын өөрчлөлт	Намын үүр
МАН	30	8.1	40.5*	161 300	8.6	1	2 (1)	11	2716
АН	20	11.7		150 000	4.7	1 (1)	1 (5)	7	502
МАХН	9	7.2		35 000	5	0	0 (3)	0	900
ХҮН	9	N/A		1 020	N/A	0	0	3	10
Дундаж	17	9		83 830	6.1	0.5 (0.25)	0.75 (2.25)	5.3	1032

* зөвхөн 2010 оноос хойших өгөгдөл

** Доогуур оноо нь үндэсний хэмжээнд хүрсэн байдал өндөр буйг илэрхийлнэ

*** Задралын тоо (хаалтанд нэгдлийн тоо)

**** Хаалтанд амжилтгүй тохиолдлууд

Хүснэгт 11-т үзүүлснээр монголын улс төрийн намууд дунджаар 17 жилийн настай байна. Бид зөвхөн олон намын тогтолцооноос хойших үеийг энд авч үзсэн гэдгийг ахин дурдая. Эдгээр дөрвөн намаас МАН ба АН насжилтийн хувьд бусад намуудаасаа илүү үндэс суурьтай гэж хэлж болно. Учир нь эдгээр намууд сонгуулиас сонгуулийн хооронд санал авч, илүү удаан оршин тогтносон юм.

Сонгогчдын тогтвортой байдлын хувьд МАН, АН, МАХН нь ойролцоо буюу тогтвортой сонгогчдын дэмжлэгтэй байв. МАН 2010 онд нэрээ сольсны улмаас зарим сонгогчдын дэмжлэгээ алдсан. Гэхдээ дараагийн хоёр сонгуулиас эхлээд сонгогчдын дэмжлэг нь тогтворжжээ. МАН ба МАХН-д коммунист үеийн өргөн тархсан суурь дэмжигчид нь чухал хэвээр буюу АН-тай харьцуулахад илүү үнэнч дэмжигчидтэй аж.

Азийн (Casal Bertoa 2017) болон бүс нутгуудын орнуудад намын дэмжлэг буурсаар байгаа (Mair, 2013). Энэ нь мөн Монголд ч харагдаж, 2010 онд 45 хувь байсан бол 2019 онд сонгогчдын дөрөвний нэг хүртэл унажээ. МАН, АН хоёр ХҮН, МАХН хоёртой харьцуулахад гишүүнчлэлээрээ илүү давуу талтай байна.

Нам үндэсний хэмжээнд хүрсэн байдлыг харгалзан үзвэл сонгогчдын дэмжлэг нь хот, хөдөөд хоёуланд нь нэлээд ижил тэнцүү хуваарилагдсан гэдэг утгаараа Монгол Улсад АН хамгийн үндэсний хэмжээний улс төрийн нам аж. МАХН хөдөө орон нутагт илүү их дэмжлэг олж чадсанаараа АН-тай ойролцоо байна. Одоогийн байдлаар бол ХҮН нь “хотын” нам аж. Сонирхолтой нь хамгийн настай, гишүүнчлэлээрээ хамгийн хүчирхэг МАН нь нийслэл хотоос илүүтэй хөдөө орон нутагт илүү дэмжлэгтэй байна. Тус намын түүхийг харгалзаж үзвэл энэ нь тийм ч гайхаад байхаар үзүүлэлт биш билээ.

Байгууллагын хувьд авч үзвэл монголын улс төрийн намууд нэлээд тогтвортой байна. Бид намуудын нэгдэл, задралаас энийг харж болох бөгөөд ардчилалд шилжсэнээс хойш ердөө хоёр задрал, нэг нэгдэл өрнөжээ. Байгууллагын залгамж халаагаар дундаж оноо 0.5 байна. Аль аль задрал нь сүүлийн арван жилд тохиожээ. Хамгийн эхлээд 2011 онд МАН-аас МАХН үүсч бий болсон бол удаах нь сүүлд болсон УИХ-ын сонгуулиар АН- аас ШИНЭ нам байгуулагджээ. АН нь өөрөө 2000 оны улс төрийн таван намын нэгдлийн үр дүн билээ. Эдгээр тохиолдлуудын аль алинд нь саналын багагүй хэсгийг шинээр үүсгэн байгуулагдсан намуудад алджээ⁷.

Хоёр дахь шалгуур үзүүлэлт болох нам сэлгэлтийг хүснэгт 8-аас харж болно. Нам сэлгэсэн амжилттай тохиолдол цөөн гарсан гэж хэлж болно. Ер нь үзэл баримтлал ойролцоо хүрээнд шилжсэн тохиолдолд л амжилттай болж байжээ. Тухайлбал МАХН- аас МАН-руу нам сэлгэхэд амжилттай байсан бол МАН-аас АН-руу сэлгэхэд амжилтгүй байв. МАН бусад намуудаасаа илүү давуу тал олсон гэж хэлж болно. Харин эсрэгээрээ нам сэлгэсэн амжилтгүй тохиолдлуудаас АН хамгийн их суларчээ.

Удирдлага өөрчлөгдсөн байдлыг харвал МАН хамгийн олон удаа удирдлагаа өөрчилсөн нь тус намын даргаа сонгох дүрэм, зан үйл нь хэвшсэн гэдгийг харуулж байна. Мөн ХҮН, АН-д ч удирдлагын өөрчлөлт гарсан ба эдгээр нь ихэнхдээ сонгуулийн ялагдлын дараагаар байв. Эцэст нь МАХН лидерт суурилсан нам хэвээр байна. Тус нам 2011 онд байгуулагдаж, МАН-ыг орхиход дарга солигдоогүй. Энэ нь мэдээж ирээдүйд намын залгамж халааны асуудалд хүргэнэ. Ийм намууд харизмтай дарга, үүсгэн байгуулагч нь улс төрийг орхих эсвэл нас эцэслэхэд уналтанд ордог тал бий.

Намын салбар, нэгжүүдээрээ МАН хамгийн давуу талтай байна. Харин эсрэгээрээ ХҮН зөвхөн хотуудад төвлөрч байна. Сонирхолтой нь АН хамаагүй удаан оршин тогтнож

7 Гэхдээ ШИНЭ нам суудал авч чадаагүй.

Монголын улс төрийн намуудын инстүүчлэл

буй атал МАХН тус намаас олон салбар, нэгжтэй аж. Дотоод үйл ажиллагаагаа зохион байгуулах тал дээр МАН түүхэн өв уламжлалаа хадгалсаар буй нь тодорхой байна.

Эцэст нь бид монголын улс төрийн намууд инстүүчлэл ялгаатай байгааг харж болно. ХҮН нийгмийн суурь (гишүүнчлэл, хөдөө орон нутгийн дэмжлэг сул), байгууллагын бүтцээрээ хамгийн залуу, сул байна. МАН хамгийн инстүүчлэгдсэн нь тодорхой байна. Гэтэл МАХН хот, хөдөө аль алинд нь илүү тогтвортой суурь дэмжигчидтэй аж. Харин АН инстүүчлэлийн хувьд дунд нь явж байна. Тус нам МАХН-аас илүү нийгэмд бат бэх суурьтай ч удирдлагын залгамж халааг нь эс тооцвол байгууллагын хувьд сул байна.

Мөн бидний судалгаанаас өөр хоёр сургамжийг авч болно. Юун түрүүнд түүхэн өв уламжлал чухал аж. МАН ба МАХН хоёул коммунист үеийн байгууллагын монополоосоо нэлээд давуу тал олжээ. Энэ нь хуучин коммунист орнууд дахь намын хөгжлийн судалгаануудтай бүрэн нийцэж буй юм (Ishiyama, 1999; Bozoki & Ishiyama, 2003).

Хоёрдугаарт монголын намын систем өндөр түвшинд инстүүчлэгдсэн нь нэг улс төрийн нам инстүүчлээс буюу МАН-ын давамгайллаас голдуу шалтгаалжээ. Хэрэв уг нам задарвал намын системийн хувьд задралд хүрэх магадлалтай харагдаж байна.

Ном зүй

- Altankhuyag, B and Gankhuyag, B (2020). Party System Institutionalization in Mongolia. Defacto Institute publishing. Ulaanbaatar
- Amarsanaa, C (2011). The front of Democratic Revolution. MN Technology. Ulaanbaatar.
- Bizzarro, F., Hicken, A., & Self, D. (2017). The V-Dem party institutionalization index: a new global indicator (1900-2015). *V-Dem Working Paper*, 48.
- Bozoki, A., & Ishiyama, J. T. (2003). The Communist Successor Parties after 1989. *Ekiert/Hanson*, 157-181.
- Casal Bértoa, F. 2012. "Parties, Regimes and Cleavages: Explaining Party System Institutionalization in East Central Europe." *East European Politics* 28: 452-72.
- Casal Bértoa, F. C., & Mair, P. (2012). Party system institutionalisation across time in post-communist Europe. *Party Gov New Eur*, 79, 85.
- Casal Bértoa, F. (2017). Political parties or party systems? Assessing the 'myth' of

institutionalisation and democracy. *West European Politics*, 40(2), 402-429.

- Dashdavaa, Ch (2001). *Brief History of Mongolian People's Party*. Sod press. Ulaanbaatar.
- Dierkes, J (2020) *Mongolia's New Parliament: Familiar Party, Fresher Faces*. The Diplomat. Retrieved from <https://thediplomat.com/2020/06/mongolias-new-parliament-familiar-party-fresher-faces/>
- Diamond, L, and Linz, J (1989). 'Introduction: Politics, Society, and Democracy in Latin America', in Larry Diamond, Juan Linz and Seymour Martin Lipset (eds.), *Democracy in Developing Countries: Latin America*. Boulder: Lynne Rienner, 1-58. *West European Politics* 425
- Dix, R (1992). 'Democratization and the Institutionalization of Latin American Political Parties', *Comparative Political Studies*, 24:4, 488-511.
- Enyedi, Z. and Casal Bértoa. 2011. "Patterns of Inter-party Competition (1990-2009)." In *Europeanizing Party Politics? Comparative Perspectives on Central and Eastern Europe*, edited by Paul G. Lewis and Radoslaw Markowski. Manchester: Manchester University Press
- Enyedi, Z (2016). 'Populist Polarization and Party System Institutionalization:
- Fish, M. S. (2001). The Inner Asian anomaly: Mongolia's democratization in comparative perspective. *Communist and Post-Communist Studies*, 34(3), 323-338.
- Fritz, V. (2002). Mongolia: Dependent Democratization. *The Journal of Communist Studies and Transition Politics*, 18(4), 75-100.
- Huntington, S (1968) *Political Order in Changing Societies*. New Haven, CT: Yale University Press.
- Herrnson, P. S. (1989). National party decision making, strategies, and resource distribution in congressional elections. *Western Political Quarterly*, 42(3), 301-323.
- Ishiyama, J. T. (1999). The communist successor parties and party organizational development in post-communist politics. *Political Research Quarterly*, 52(1), 87-112.
- Janda, K (1980) *Political Parties: A Cross-National Survey*. London: Macmillan.
- Johnson, E. P. (2002). *Streams of least resistance: the institutionalization of political parties and democracy in Indonesia*. University of Virginia.
- Lewis, P (1994). 'Democratization and Party Development in Eastern Europe', De-

mocratization, 1:2, 391–405.

- Levitsky, S (1998) 'Institutionalization and Peronism: The Concept, the Case and the Case for Unpacking the Concept', *Party Politics* 4: 77–92.
- Mainwaring, and Scully (1995). *Building Democratic Institutions: Party Systems in Latin America*. Stanford: Stanford University Press.
- Mair, P., & Van Biezen, I. (2001). Party membership in twenty European democracies, 1980–2000. *Party politics*, 7(1), 5–21.
- Mainwaring, Guillermo and Samuel (1992). 'Introduction', in Scott Mainwaring, Guillermo O'Donnell and Samuel Valenzuela (eds.), *Issues in Democratic Consolidation: The New South American Democracies in Comparative Perspective*. Notre Dame: University of Notre Dame Press, 1–16.
- Mainwaring, S and Scully. T (1995) *Building Democratic Institutions: Party Systems in Latin America*. Stanford, CA: Stanford University Press.
- McGuire, J (1997). *Peronism without Perón: Unions, Parties, and Democracy in Argentina*. Stanford: Stanford University Press.
- Mongolian People's Party (2011). *History of Mongolian People's Party I-VII*. Ulaanbaatar.
- Panebianco, A (1988) *Political Parties: Organization and Power*. Cambridge: Cambridge University Press.
- Randall, V., & Svåsand, L. (2002). Party institutionalization in new democracies. *Party politics*, 8(1), 5–29.
- Torbati, Y. (2016, 6 5). *Kerry hails Mongolia as 'oasis of democracy' in tough neighborhood*. Retrieved from The Reuters: <https://www.reuters.com/article/us-usa-mongolia-idUSKCN0YR02T>
- Van Biezen, I., Mair, P., & Poguntke, T. (2012). Going, going,... gone? The decline of party membership in contemporary Europe. *European journal of political research*, 51(1), 24–56.
- Zaankhuu.J (2004). *Some materials related to the Democratic Revolution in 1990*. Ulaanbaatar.

Хавсралт 1.

Хүснэгт 12. Намуудын авсан саналын хувь хэмжээ ба суудлын тоо (1992-2020)

Намууд	1992		1996		2000		2004	
	Санал (%)	Суудал	Санал (%)	Суудал	Санал (%)	Суудал	Санал (%)	Суудал
МАН	53.4%	70	40.5%	25	51.0%	72	48.0%	36
АН	26.7%	5	47.8%	50	25.3%	1	44.1%	34

Намууд	2008		2012		2016		2020	
	Санал (%)	Суудал	Санал (%)	Суудал	Санал (%)	Суудал	Санал (%)	Суудал
МАН	43.1%	39	31.3%	25	45.1%	65	45.0%	62
АН	39.4%	25	35.3%	31	33.1%	9	24.5%	11
МАХН	N/A	N/A	22.3%	11	8.0%	1	8.1%	1
ХҮН	N/A	N/A	N/A	N/A	N/A	N/A	5.2%	1

ТАЛАРХАЛ

Стратеги Академи, Фридрих-Эбертийн сангийн захиалгаар энэхүү судалгааны ажлыг хийж, гүйцэтгэсэн Ноттингхам Их Сургуулийн Профессор Фернандо Касал Бэртуа, Дефакто Институтын Ахлах судлаач А.Бат-Оргил, туслах судлаач Г.Батхишиг болон судалгааг хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн Фридрих-Эбертийн сангийн хамт олонд гүн талархал илэрхийлье.

СТРАТЕГИ АКАДЕМИ

Хамтран ажилласан байгууллагууд:



